

11. А.Анударь: Бэлгийн дарамтыг сүржигнэлээ гэх нь хүчирхийллийн хөрсийг бэлдэж буй хэрэг юм. <https://gogo.mn/r/77y8o>.

СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ҮДИЙН ХООЛ ХӨТӨЛБӨРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Д. Оюунцэцэг

МУИС-ийн Социологи Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш

Orcid:0009-0008-8140-538X

Abstract: *This article explains legal regulations of the implementation of school lunch program, the current situation of funding of the meal program and the possibilities for its continuity based on the parent's opinion conducted by Sociology and Social Work department of NUM in frame of specialization practice. 558 parents participated in the study and the research shows that cost for per student's meal was not enough, parents do not hesitate to contribute some cash their children's meal, however the current form and control needs to be improved. The article includes legal regulations, cost analysis and parent's opinion.*

Key words: *School meal program, Law of school food service, funding*

Үдийн хоол хөтөлбөрийн эрх зүйн зохицуулалт

Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд явагдаж байна. Тухайлбал, ЕБС-ийн хоол үйлчилгээний тухай хууль. 2019 оны 05.30 батлагдсан, ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр 2020 оны 6.1 Дугаар 207, Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн 24.2 т зааснаар ‘Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан’, Боловсрол, Шинжлэх Ухааны сайд, Эрүүл Мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал (А/166, А/559, 222) 2020 оны 12 дугаар сарын 02-нд баталжээ. Эдгээр хууль, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дэвшүүлсэн зорилгыг хангахтай холбоотой дараах стандартыг баталсан. Үүнд: ЕБС-ийн хоол аюулгүй байдлын стандарт MNS 6728: 2019, ЕБС-ийн дотуур байрны орчин үйлчилгээний стандарт MNS 6799:2019, Цэцэрлэг ЕБС-ийн орчин үеийн эрүүл ахуйн стандарт зэрэг батлагдсан.

ЕБС-ийн хоол үйлчилгээний тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжүүлэх дөрвөн зорилт бүхий төлөвлөгөөг ханган ажиллахад чиглэсэн сургуулийн хоол хөтөлбөрийн хүрээнд дагаж мөрдөх 5 тушаал шийдвэр, 5 журам, 11 судалгааны ажил, 7 сургалт, 3 үйл ажиллагаа, холбогдох цахим сан, гарын авлага, хөтөлбөр гэсэн агуулгаар үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг зохиосон байна. Үйл ажиллагааны төрлүүдээс дүгнэхэд судалгаанд суурилсан шийдвэр гаргах, үйл ажиллагааг цааш төлөвлөхөд анхаарсан байна.

ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль: Монгол улсын Их Хурлын 2019 оны хаврын чуулганаар ‘ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль’-ийг 2020 оны 9 сарын 1-ний

өдрөөс дагаж мөрдөхөөр батласан. Тус хуулийн 4.1-д зааснаар ЕБС-ийн сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй (цаашид сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ гэх) холбоотой харилцаанд үйлчилэхийг тодотгосон. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах нэгж ажиллана. Бага анги 2021-2022 оны, дунд анги 2022-2023 оны, ахлах анги 2023-2024 оны хичээлийн жилээс тэгш хамрагдана. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаар а) Засаг дарга, б) аймаг нийслэлийн боловсрол эрүүл мэндийн газар в) хөндлөнгийн хяналт 'Хяналтын зөвлөл', г) дотоод хяналтыг сургууль хэмээн заасан байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ; 10.5.1-10.5.4-р заалтад нутаг дэвсгэрийнхээ сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах, арга хэмжээг хэрэгжүүлэх; мэргэжлийн бүтэц орон тоогоор хангахад дэмжлэг үзүүлэх; сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэхэд; орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтвортой явуулах арга хэмжээг зохион байгуулах;

Сургуулийн захирал сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар 10.7-д зааснаар: хоол зүйч тогочийг давтан сургах, хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлыг хангах, хоол үйлдвэрлэл үйлчилгээг холбогдох хууль, тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах, шаардлагатай зардлын хувиарлалтыг явуулах зэрэг болно.

ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, Үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр: Сургуулийн хүүхдийн хоол хөтөлбөрийн зорилго нь хүн амын дунд хоол тэжээлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, зонхилох халдварт бус өвчнөөс сэргийлэн бичил тэжээлийн дутлыг бууруулна (Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2010).

I-р үе шат (2021-2030) : Эрүүл баталгаат орчин бий болгох үе

II-р үе шат (2031-2040): Амьдралын таатай орчин бүрдүүлэх үе шат

III-р үе шат (2041-2050): Амьдралын хэрэгцээ хангагдсан орчин бүрдүүлэх үе

2020 оны 6 сарын 1 нд батлагдсан МУЗГ-ын 207-р тогтоолын хавсралтаар 2020-2025 онд хэрэгжих уг хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн гол зорилго нь ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй, тогтвортой, хүртээмжтэй тогтолцоог бий болгох, суралцагчийг шим тэжээллэг хоол, хүнсээр хангаж, эрүүл мэндийг нь дэмжих, хамрах хүрээг өргөжүүлэх юм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг холбогдох яам, агентлагууд жил бүрийн 12 дугаар сард багтаан гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн Төрийн Захиргааны Төв Байгууллагад ирүүлнэ хэмээн заасан байна. Уг хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тодорхойлохоор хөтөлбөрт тусгасан.

Хүснэгт 1. 'ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, Үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр'-ийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилгот түвшин
1	ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлдэгтэй холбогдон гарах эрх зүйн баримт бичгийн тоо	тоо	0	12
2	Сурагчдыг стандарт шаардлага хангасан ундны усаар үнэ төлбөргүй хангасан сургуулийн эзлэх хувь	хувь	56	100

3	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх орон нутгийн болон дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь	хувь	15	60
4	Үдийн хоолонд бүрэн шилжсэн сургуулийн эзлэх хувь	хувь	20	100
5	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээллийн сан бүхий цахим систем	тоо	0	1
6	Хоол зүйчээр хангагдсан сургуулийн тоо	тоо	7	600
7	Мэргэжлийн тогоочоор хангагдсан сургуулийн тоо	тоо	99	662
8	6-11 насны хүүхдийн өсөлт хоцролтын тархалтын хувь	хувь	7.3 (2017 он)	5.0
9	Хоол, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийх нэвтрүүлгийн тоо	тоо	1	25
10	Боловсролын үйлчилгээнд оролцогч талуудад зориулсан хөтөлбөр, хэрэглэгдэхүүн	тоо	0	3

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг орон нутгийн хэмжээнд чанартай хэрэгжүүлж ажиллах тухай Засаг дарга нарт зөвлөсөн.

Сургуулийн хоол хөтөлбөрийн зорилго: ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй, тогтвортой хүртээмжтэй тогтолцоог бий болгох, сурацагчийг шим тэжээллэг хоол хүнсээр хангаж эрүүл мэндийг нь дэмжихэд оршино. Энэхүү зорилгынхоо хүрээнд дараах 4 зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

Зорилт 1. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ХАА-н үйлдвэрлэлд тулгуурласан, стандартын шаардлага хангасан хоол, хүнсний хангамжийн тогтолцоо бүрдүүлэх.

Зорилт 2. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлагад нийцүүлэх, хөндлөнгийн болон, дотоод хяналтыг сайжруулах замаар хоол хүнсний аюулгүй байдлыг хангах

Зорилт 3. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх.

Зорилт 4. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээгээр дамжуулан боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хоол, шим тэжээлийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх... гээд тухайн зорилт тус бүрд хийгдэх ажлуудыг нэгбүрчлэн зааж өгсөн байна. Төрийн өмчийн сургуулиудаас, хоолны газраа өөрсдөө ажиллуулдаг 516 сургууль, хоолны газаргүй стандартын шаардлагад нийцээгүй зориулалтын бус хоолны газартай 206 сургууль байна (БСШУЯ, ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ: Үдийн цайнаас-Үдийн хоол, 2020)

Дараах 7 сургалтыг төлөвлөсөн:

- *Үндэсний стандартын шаардлага хангасан тохирлын гэрчилгээтэй, орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх сургалт*
- *Сургууль, дотуур байрны хоол үйлдвэрлэлд нийлүүлэх дотоодод үйлдвэрлэсэн ХАА-н гаралтай түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах*
- *Хүнс ханган нийлүүлэгчдэд зориулсан ХАА-н болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх чиглэлээр сургалт*
- *НАССР 'Hazard analysis Critical Control Point' болон зохистой дадал нэвтрүүлсэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний туршлагыг түгээн дэлгэрүүлэх*

- Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах мэргэжлийн хүний нөөц бэлтгэж буй сургалтын тогтолцоог сайжруулах бодлогоор дэмжих
- Баги ажилчид, эцэг эх, асран хамгаалагчийн хоол шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр нэвтрүүлэг сургалт
- Сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгааны дүнд үндэслэн хүүхдийн зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргах, сургалт зохин байгуулах

Дараах 3 үйл ажиллагааг төлөвлөсөн: Орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалалт, борлуулалтын үйл ажиллагааг бодлогоор дэмжих (ХХААХҮЯ, Аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга 2020-2022), Сургууль дотор стандартын шаардлага хангасан ундны усаар үнэ төлбөргүй үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх (БШУЯ, ОУБ, ААН, Аймаг Нийслэлийн засаг дарга Сургуулийн захирал 2020-2025), Сургуулийн дэргэдэх туслах АА-г хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Аймаг нийслэл сум дүүргийн ИТХ, Засаг дарга, Сургуулийн захирал 2021-2025),

Холбогдох цахим сан, гарын авлага, хөтөлбөр: Орон нутагт хүнсний түүхий эдийн худалдан авалтын болон хяналтын цахим систем боловруулах, турших (БШУЯ8 ХХААХҮЯ, ШУТИС, Шим тэжээл судлалын төв, ОУБ 2021-2022), Сургуулийн үдийн хоолны жор бүхий гарын авлага боловсруулах (БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, ШУТИС, ШИМ тэжээл судлалын төв 2020-2023), ЕБС-ийн сурагчдад хоол шим тэжээлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг сайжруулж, төлөвлөгөө, модуль хэрэглэгдэхүүн боловсруулах (БШУЯ, Холбогдох мэргэжлийн байгууллага 2020-2023)

Боловсрол, Шинжлэх Ухааны сайд, Эрүүл Мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал (А/166, А/559, 222)

Тус 3 яамны сайдын тушаалаар ‘Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт, цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ’ мөн ЕБС-ийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг баталсан байна. Тус жишиг хэмжээнд зааснаар илчлэгийн хэмжээг дараах байдлаар үзсэн байна.

Хүснэгт.2. Хоногт авах илчлэгийн хэмжээг хувиар

1	Өдрийн цаг буюу 8 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд	80 хувь
2	24 цагийн үйл ажиллагаатай сувилал, цэцэрлэгийн хүүхэд (хүүхдийн биеийн хөгжлийн онцлогоос хамаарна)	100 хувь (±10 хувь)
3	ЕБС-ийн дотуур байранд амьдардаг	100 хувь
4	ЕБС-ийн ‘Үдийн цай’ хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхэд	15 хувь
5	ЕБС-ийн ‘Үдийн хоол’ хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхэд (хүүхдийн хөдөлгөөний идэвх, биеийн хөгжлийн онцлогоос хамаарна)	35 хувь (± 10 хувь)

Хоногийн хоолны илчлэг өглөөний хоолонд 20-25 хувь, бага үдийн цай 10-15 хувь, үдийн хоолонд 35-40 хувь, их үдийн цай 10-15 хувь, оройн хоол, цайнд 20 хувийг тус тус авдаг хэмээн тус А/166 тоот тушаалын хавсралтад баталсан байна. Энэ тушаалаар 7-10, 11-14, 15-18 насны ЕБС-ийн сурагчдын хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг мах, сүү, цагаан идээ, тараг, гурил гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, хүнсний ногоо, буурцагт ургамал, жимс жимсгэнэ, ургамлын тос, цөцгийн тос, сахар чихрийн зүйл гэсэн үзүүлэлтээр хоногт хэрэглэх хэмжээг заан уураг тос, нүүрс ус, илчлэгийг нь бодон гаргасан байна. 7-10 насныхны хоолонд хамгийн өндөр ккал- тай байх бүтээгдэхүүнд гурилан бүтээгдэхүүн (319 ккал), төрөл

бүрийн будаа (248 ккал), гурил (228 ккал) байхаар тус тус заагдсан байна. (Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын хамтарсан тушаал, 2020)

Сургуулийн хоол хөтөлбөрийг явуулах хууль, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө зэргийг баталснаар сургууль өөрөө эрх бүхий байгууллага болж харагдаж байгаа ч, хоол хөтөлбөрөө сургууль өөрөө хэрхэн дэмжин ажиллах талаар Боловсролын Ерөнхий хууль, Хоол үйлдвэрлэл үйлчилгээний хуулиудтай хэрхэн нийцүүлэх нь тодорхойгүй байна.

Боловсролын Ерөнхий хуулинд

37.4.Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн сургалтын орчин, үйл ажиллагааг дэмжсэн туслах аж ахуйтай байж болох бөгөөд түүнээс олсон орлогоо зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч хэрэгжүүлэнэ. (БСШУЯ, Боловсролын ерөнхий хууль, 2023)

Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль

7.5.Сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний хангамжид хэрэглэх түүхий эд, бүтээгдэхүүнийг сургуулийн дэргэдэх туслах аж ахуйгаас бэлтгэж болох бөгөөд туслах аж ахуй нь сургалт-туршилтын талбай бүхий ашгийн төлөө бус байна.

2019 онд батлагдсан үдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн 7.5-д зааснаар сургуулийн хоол үйлдвэрлэл, хүнсний хангамжид хэрэглэх түүхий эд бүтээгдэхүүнийг сургуулийн дэргэдэх туслах аж ахуйгаас бэлтгэж болох ч сургалт- туршилтын талбай нь ашгийн төлөө бус байна хэмээсэн. Гэтэл Боловсролын Ерөнхий хуулийн 37.4 зааснаар боловсролын байгууллага нь туслах аж ахуйтай байж болно, орлогоо зориулалтын дагуу захиран зарцуулна гэж хуулиндаа тусгасан. Эндээс сургууль аж ахуйн үйл ажиллагаа явуулсан ч ашгийн төлөө бус байна гэхээр ямар зохион байгуулалттай байхыг эрх зүйн хувьд тодорхой болгох шаардлага харагдаж байна.

Сургуулийн хоол хөтөлбөрийн үйлчилгээ, зардалд хийсэн шинжилгээ

Улс орон бүр хүүхдээ сургуульд хамруулахын сацуу, шим тэжээлтэй хоолоор хангах асуудлыг хөнддөг. Доорх хүснэгтээс ОХУ, АНУ, Япон, БНСУ-ын хүүхдийн хоол хөтөлбөрөө зохион байгуулж буй хэлбэр болон удирдах, хяналт тавих, мөрддөг хууль эрх зүйн баримт бичгүүд, хангамжийн эх үүсвэрээр судаллаа. Сургуулийн хоол үйлчилгээний хуулийг АНУ 78 жилийн өмнө, Япон улс 70 жилийн өмнө хэрэгжүүлж олон жилийн туршлагыг хуримтлуулжээ. Удирдах байгууллагын хувьд Монгол улс БСШУЯ, ЭМЯ хамтран хариуцаж байгаа нь бусад орнуудаас ялгаатай. Зохион байгуулалтын хэлбэрийн хувьд бусад улс орнууд хоол хүнсний нэгдсэн комбинатаас сургуулийн гал тогоонд хүнсний бүтээгдэхүүн нь ирдэг бол, Монгол улсад сургууль бүр өөрсдөө бүтээгдэхүүнээ худалдан авч боловсруулж хоол үйлдвэрлэлээ явуулж байна. Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд бусад улс орнууд улсаас болон эцэг эхээс гэсэн хэлбэрээр явж байхад Монгол улсад өнөөгийн байдлаар зөвхөн улсын зардлаар хүүхдийн хоолны санхүүжилтийг хангаж байна. Түүнчлэн сургуулийн хоол үйлчилгээнд гарч буй зардлыг хуваалцахад тоног төхөөрөмжийг ЗГ, орон нутаг, хоолны түүхий эдийг эцэг эхүүдээс, үйл ажиллагааны зардлыг Боловсролын Яам хангадаг БНСУ-ын загвараас дүгнэхэд улс бүх зардлыг өөртөө төвлөрүүлэхгүй байхыг, хөтөлбөрийг олон жилээр үргэлжлүүлэхэд илүү анхаарч байгаа нь анзаарагдаж байна.

Тиймээс цаашдаа Монгол улс ч энэ чиглэл үрүү явах нь хөтөлбөрийг урт хугацаанд тогтвортой дэмжих мөн хөтөлбөрийн чанар үр ашгийг дээшлүүлэх, нийгмийн тэгш бус байдлаас улбаатайгаар

нэг хүүхдийн хоолны зардлыг ялгамжтайгаар тогтоох, эцэг эх асран хамгаалагчдын үүргийг өндөржүүлж, хүүхэддээ өглөөний цайг нь гэрт нь уулгадаг болгоход сургах, өдрийн хоолны зардлын тодорхой хувийг тэднээс гаргуулдаг болсноор энэ хөтөлбөр урт хугацанд тогтвортой явах нь тодорхой байна.

Хүснэгт 2. Хүүхдийн хоол хөтөлбөрийн зохион байгуулалтыг улс орноор харьцуулсан нь

№	Үзүүлэлтүүд	ОХУ	АНУ	Япон	БНСУ	Монгол улс
1	Үдийн хоолны үйлчилгээний хэрэгжилтийн байдал	2007 оноос хөтөлбөр хэрэгжүүлсэн. 2011 оноос шинэчлэл хийгдэж байна.	1932 онд эхэлсэн. 1946 онд үдийн хоолны тухай хууль батлагдсан.	1947 онд эхэлсэн. 1954 онд сургуулийн үдийн хоолны тухай хууль батлагдсан.	1953 онд баталсан. 1981 онд сургуулийн хоол үйлчилгээний хууль баталсан. 2001 оноос НАССР нэвтрүүлсэн.	2006 оноос эхэлсэн 2019 онд ЕБС-ийн хоол үйлчилгээний хууль батлагдсан
2	Мөрддөг хууль, дүрэм журам	2008 онд эрүүл ахуйн дүрэм 2012 онд сургуулийн хоол үйлчилгээний стандарт	Сургуулийн үдийн хоолны хөтөлбөр Шим тэжээлийн хууль	Сургуулийн үдийн хоолны тухай хууль	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль	ЕБС-ийн хоол үйлчилгээний хууль, Боловсролын хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Баяжуулсан хүнсний тухай хууль, эрүүл ахуйн тухай хууль, органик хүнсний тухай хууль зэргийг мөрдөнө
3	Хангамжийн эх үүсвэр		Хуулиндаа дотоодын түүхий эд хэрэглэхийг	Дотоодын хүнсний үйлдвэрүүд	Дотоодын хүнсний үйлдвэрүүд	Дотоодын түүхий эд, хүнсээр
4	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсаас Эцэг эхээс	Улсаас Эцэг эхээс	Орон нутгийн захиргаа 2/3 хувийг Эцэг эхээс 1/3 хувийг бараа худалдан авалт тээвэрлэлтийн зардлыг үйлчилгээ үзүүлдэг компани хариуцдаг.	Тоног төхөөрөмжийг засгийн газар, орон нутгийн захиргаа Хоолны түүх эдийн зардлыг орон нутгийн захиргаа эцэг эх Үйл ажиллагааны зардлыг Боловсролын яамнаас хариуцдаг.	ЕБС-ийн хоол үйлчилгээний хуулинд: 5.1.1 Улсаас, орон нутаг 5.1.2 Гадаадын зээл, буцалтгүй тусламж 5.1.3 ОУБ, төсөл хөтөлбөрийн санхүүжилт 5.1.4 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 5.1.5 Бусад эх үүсвэр Одоогоор зөвхөн төрөөс
5	1 хүүхдийн хоолны зардал	145 RUB (5288 ₮)	\$ 2.83 (9553 ₮)	250 JPY (5557.5 ₮)	4699 KRW (11700 ₮)	1500 ₮

2024. 04.09 ны өдрийн ханиаар тооцон мөнгөн дүнг монгол ₮ хөрвүүлээ.

ОХУ, АНУ, Япон, Солонгос зэрэг улсуудын нэг хүүхдийн хоолны зардалд зарцуулж буй мөнгөн дүнгээ тогтоож байгаа байдлаас харахад нь муж бүртгээ харилцан адилгүй, тухайн мужийн засаг захиргаа тооцон гаргаж байна. Тухайлбал, ОХУ 142-148 рубль (5288 ₮) хэмээн тогтоодог, өглөөний цай үдийн хоол хоёуланд нь хамрагддаг бол үнэ нь өөр байдаг. Харин Солонгос улс 4699 вон (11700₮) нь Сөүл хотын хэмжээнд гаргасан нэг сурагчид ноогдох хоолны зардал байна. Дээрх харьцуулалтаас дүгнэхэд амжиргааны түвшнээр ялгамжтай үнийн бодлого барих, муж бүрийг

өөрсдийнх нь нөөцийг дайчлуулах, эцэг эхчүүдийн оролцоог дэмжсэнээр урт хугацаанд уг хөтөлбөрийг хөгжүүлэх үзэл баримтлал дээр дурьдсан улс орнуудад байгааг манай улс авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Миний сонирхон судалж буй зохион байгуулалтын хэлбэрүүдийн хувьд сургуулийн гал тогоо хоолны заалаар хүүхдийн хоолоо олгодог нь дээр дурьдсан орнуудад түгээмэл байна. Бага дунд ахлах ангийн хүүдүүдийг хоолны үеэр чөлөөтэй яриулах, суулгах, нөхөрлөх боломжийг олгох үүднээс хоолны газрын зохион байгуулалт, ялангуяа ширээний уян хатан байдалд илүү их анхаарч, ганцаараа, хоёроороо, 5-6 сурагчид нийлээд суух боломжтой байдлаар зохион байгуулалт хийдэг болсон байна.

Дээр дурьдсан орнуудаас Монгол улсын ялгаатай байдал нь хүүхдийн хоолны зардлыг зөвхөн төр дааж байгаагаараа онцлог байна. Бид цаашдаа нэг л эх үүсвэртэй байх уу? эсвэл олон эх үүсвэрүүдийг бүрдүүлэх боломжийг эрж хайх уу? гэдэгт хариу өгөхийн тулд хүүхдийн хоолны нэрлэсэн дүнгээр олгогдож байгаа өнөөгийн зардалд шинжилгээ хийж үзье.

Үдийн цай хөтөлбөрөөс Үдийн хоол хөтөлбөр болж хөгжих хүртэлх 18 жилийн хугацаанд нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг нийтдээ 4 удаа, хүүхдийн хоолонд хамрагдах хүүхдийн анги бүлэг 3 удаа өөрчлөгдсөн байна. Анги бүлэгтэй холбоотой өөрчлөлтүүд нь 2005-2006 онд ЕБС-ийн 1-2 анги, 2006-2007 онд 1-4 дүгээр ангийн сурагчдад, 2012-2013 онд 1-5 ангийн сурагчдыг хамруулах болсон. Нэг сурагчид ноогдох хоолны зардлыг 300 ₮-өөр тогтоон 2006-2007 ба 2007-2008 оны хичээлийн жилд эхэлсэн бол, анхны өөрчлөлтийг 2008 оны 01 сарын 45 тоот тогтоолоор 400 ₮ болгон өөрчилсөн төдийгүй хамрах ангийн сурагчдыг I-V анги болгосон байна. Дараагийн өөрчлөлт нь 2012 оны МУЗГ-ын 106-р тушаалаар гарч, ‘Үдийн цай’ хөтөлбөрийн нэг хүүхдийн зардлыг 600 ₮ болгосон. Гуравдахь өөрчлөлт нь 2019-2020 оны хичээлийн жилд хүүхдийн хоолны зардал 300 ₮-өөр нэмэгдэн 900 ₮ болсон байна. Дөрөвдэхь өөрчлөлт нь ЕБС-ийн хоол үйлчилгээний тухай хууль 2019 батлагдсанаар нэг хүүхдэд ноогдох зардлыг 1500 ₮ болгон нэмэгдүүлсэн байна.

Нэг хүүхдэд ноогдох хоолны зардал болох 1500 ₮ хүүхдэдээ бүрэн очиж чаддаг эсэхийг инфляцтай уялдуулан судаллаа. Инфляцыг тооцдог 2 арга байдаг. Эхнийх нь хэрэглээний үнийн индексээр (CPI), хоёрдах нь ДНБ-ээр дамжуулан тооцоолол хийдэг. 2006-2024 оны 18 жилийн хугацаанд хүүхдийн хоолны зардалд олгосон мөнгөн дүн хангалттай хэмжээнд өссөн мэт харагдаж байгаа боловч, сургуулийн хоол үйлчилгээний хуулиндаа .. *Сургуулийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг инфляцын түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах* (БСШУЯ, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль, 2019, 10.1.1) гэж заасан ч, жил бүр олгогдох санхүүжилт инфляцыг тооцож олгоогүйг хүснэгт 3-аар харууллаа.

Хүснэгт 3. Хүүхдийн хоол хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо, зардлын өөрчлөлт, нийт олгосон мөнгөн дүнг инфляц тооцсон үзүүлэлт

Хичээлийн жил	Анги	Хоолны зардал 1 хүүхдээр	Хүүхдийн тоо	Санхүү тэрбум ₮	Тухайн жилийн инфляц	Инфляц (CPI) Тооцсон мөнгөн дүн	Инфляц тооцсоны дараах мөнгөн дүн
2006-2007	I-II	300	116800	4.2	6.2		
2007-2008	I-IV	300	196000	9.6	17.8		
2008-2009	I-V	400	239800	16.5	22.1		
2009-2010	I-V	400	280400	19.2	4.2		
2010-2011	I-V	400	265700	16.2	13		

2011-2012	I-V	400	255900	16.7	8.9		
2012-2013	I-V	400/600	255988	17.5/24.7	14		
2013-2014	I-V	600	239289	24.5	12.5		
2014-2015	I-V	600	251204	-	10.4		
2015-2016	I-V	600	271687	25	1.9		
2016-2017	I-V	600	288345	24.4	1.3		
2017-2018	I-V	600	309355	25.8	6.4		
2018-2019	I-V	600	327019	27.7	8.1		
2019-2020	I-V	600/900	342634	15.2	5.2		
2020-2021	I-V	900/1500	356904	21.9	2.3	1578	1422
2021-2022	I-V	1500	371480	77.3	13.8	1614	1386
2022-2023	I-V	1500	382002	77.9	13.2	1837	1163
2023-2024	I-V	1500	381481	86.7	7.9	2080	920

Тухайлбал, 2020 онд 1500 ₮ болж өөрчлөгдсөнөөс хойш инфляц тооцсон дүнгээр тооцоолол хийвэл жил бүр нэг хүүхдэд ноогдох хоолны зардал 2021-2022 оны хичээлийн жил 1614 ₮, удаах жил нь 1837 ₮, харин 2024 онд 2080 ₮ болж хүүхдийн хоолонд очих байсан. Энэ тооцооллоос 2023-2024 оны хичээлийн жил нэг хүүхдийн хоолны зардалд 580 ₮ (2080-1500=580₮) нэмж тооцогдох ёстой ч, эсрэгээрээ одоогийн олгогдож байгаа 1500 ₮ нь инфляцид өртөж (1500-580=920 ₮) нэг хүүхдийн хоолны зардалд 920 ₮ бодитоор хоол болон очиж байна. Үүнээс үүдэн гарах сөрөг үр дагаврууд нь хүүхдийн хоол чанаргүй, хүүхдийн хоолонд олон төрлийн бүтээгдэхүүн байдаггүй, мөнгө нь огт хүрдэггүй, ашиг гарахгүй байна зэрэг олон асуудлыг өөртөө агуулж байгаа нь илт байна. Тиймд 2024-2025 онд инфляц тооцоогүй мөнгөн дүнгээр нэг хүүхдийн хоолны зардал тооцогдвол энэ хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн энэхүү санхүүжилтээс шууд хамааралтайг илтгэж байна.

Үдийн хоол хөтөлбөртэй холбоотой эцэг эхчүүдийн санал бодол

Үдийн хоол хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд эцэг эхийн зөвлөл, хяналтын зөвлөлийн үүргийг хуульд тусгахдаа орон тооны бус хяналтын зөвлөлд эцэг эхчүүдийг багтаасан. ..Орон тооны бус хяналтын 'Зөвлөл' ажиллах бөгөөд суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл гурав, суралцагч, багшийн төлөөллийг оролцуулан нийт таван хүний бүрэлдэхүүнтэй байхаар тусгасан байна (БШУЯ, 2020, р. 5). Төлөөллийг сонгохдоо эцэг эхийг эцэг эхийн хурлаас, багшийг багш нарын хурлаас, суралцагчийг сурагчдын зөвлөлийн хурлаас сонгоно. Зөвлөл нь хооллох танхим, хооллох нөхцөл, ариун цэврийн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар хяналт тавих; батлагдсан хоолны цэсийн дагуу үйлчилгээ үзүүлж байгаа эсэхийг хянах; хооллох соёл, хоолны шим тэжээлийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад сургуулийн удирдлагад дэмжлэг үзүүлэх хэмээн заажээ (8.3.1-8.3.3).

Гэвч бодит байдалд эцэг эхчүүдийн мэдлэг оролцоо ямар байгааг 2019 оны МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын гэнхмийн мэргэших дадлагын хүрээнд хийгддэг нийгэм эдийн засгийн судалгаанд Үдийн хоол хөтөлбөртэй холбоотой асуултуудыг оруулж, тэдний хандлагыг тандсан юм. Судалгаанд 1-5 р ангийн хүүхэдтэй нийт 558 эцэг эх Улаанбаатар хотоос 227, орон нутгаас 331 хамрагдсанаас эрэгтэй 41.2 хувь, эмэгтэй 58.8 хувьтай, дээд боловсролтой ээж аавууд хамгийн их 48.4 хувьтай, бүрэн дунд боловсролтой 35.7 хувьтай, бүрэн бус дунд, бага, боловсролгүй нь 7.5 хувьтай байсан. Эцэг эхчүүдийн 28.9 хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг бол хувийн компанид, хувиараа хөдөлмөр эрхэлдэг нийлээд 45.5 хувь, малчид 7.5 хувь, тэтгэвэрийн, эрхэлсэн ажилгүй, суралцагсад 13.1 хувийг эзэлж байна. Оролцогсдын 78 хувь өөрсдийгөө нийгмийн дунд давхраанд хамруулсан нь хамгийн өндөр хувьтай, дундаас дээгүүр давхраанд 13.1 хэмээн үнэлжээ.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ өглөөний цайг уулгаад сургуульд явуулдаг эсэхийг тандахад нийт эцэг эхчүүдийн 62.9 хувь нь өдөр бүр уулгадаг, дөнгөж 3.2 хувь нь үгүй гэж хариулсан нь хүүхдийнхээ боловсролыг дэмждэг, хариуцлагатай эцэг эхчүүд хөдөө хот ялгаагүй судалгаанд оролцсоныг илтгэж байна. Харин судалгаанд оролцсон 558 эцэг эхчүүдээс сурагч байхдаа өглөөний цайгаа уудаг нь 463, огт уудаггүй 95 эцэг эх оролцсоноос тэдний ихэнх нь өглөөний цайнд ач холбогдол өгдөг зөв дадалтай байсан байна.

Дүрс 1. ЕБС-д суралцаж байхдаа өглөөний цайгаа уудаг байсан эсэхийг нийгмийн давхраажлаар



Мөн түүнчлэн хүүхэд үдийн хоолонд хамрагддаг болсноор хоолны өмнө гараа угаахад суралцсан, хичээлдээ явах дуртай болсон, хоолоо гэр бүлийнхэнтэйгээ идэх гэдэг болсон, асуудлуудаа ярьдаг болсон гээд эерэг үр дагаваруудыг эцэг эхчүүд сайшаан өгүүлсэн байна. Тиймд хоол бол хүүхдийн бие бялдар суралцахад нөлөөлөхөөс гадна түүнийг нийгмийн харилцаанд суралцуулахад үлэмж үүрэгтэйг энэхүү судалгаа харууллаа.


Эцэг эхчүүдийн 80 хувь нь сургуулийн хоол хангалтгүй байгааг мэддэг учраас өдөр бүр нэмэлт мөнгө өгдөг хэмээн хариулснаас 44.1 хувь нь хүүхдүүд үдийн хоолондоо цаддаггүй, 36.1 хувь нь амт чанар тааруу гэж үзжээ.

Дүрс 2. Хүүхдийн хоолонд эцэг эхчүүдийн өдөр бүр өгдөг мөнгөн дүнг нийгмийн давхраажлаар



Эдгээр эцэг эхчүүдийн 75 аас дээш хувь өөрсдийгөө дунд давхраанд хамааруулсан бөгөөд хүүхдийнхээ хоолонд өгч буй мөнгөний тоо нь харилцан адилгүй. Тэдний 80.8 хувь нь 2000-3000 ₮ өгдөг гэсэн хамгийн өндөр хувьтай байна. Харин 2023 онд БШУЯ-ны хоол үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсээс үдийн хоол хөтөлбөрийн чуулганд зориулан явуулсан цахим асуумжаар эцэг эхчүүд хүүхдийн үдийн хоолонд сард ойролцоогоор 29862 ₮, өдөрт 1357 ₮-ийг нэмж өгдөг гэсэн дүн гарсан байна.

Дүрс 3. Хоолны зардалд эцэг эхчүүдийн өгдөг мөнгөн дүн (нэг сараар)



БШУЯ Хүүхдийн Үдийн хоол чуулганд зориулсан цахим асуулга-2023 он

Энэ дүн нь байршлаас шалтгаалаад янз бүр байгааг дараах хариултаас харж болно. УБ хотын СБД-ийн эцэг эхчүүд сард хүүхдэддээ өгч байгаа мөнгө нь хамгийн их 2039 ₮ байгаа бол, удаах нь Баянгол дүүрэг 1804 ₮, Увс аймаг хамгийн бага өдөрт 1080 ₮ өгдөг хэмээсэн байна. Эндээс МУИС-ийн Социологи, Нийгмийн ажил тэнхмийн судалгаа, Боловсролын яамны асуулгаас эцэг эхчүүд өдөрт 1357 ₮-2000 ₮ ийг хүүхдийнхээ үдийн хоолны зардалд нэмэгдэл болгон өгч байгааг төрөөс төсөвлөсөн 1500 ₮ бус, хүснэгт 3-т үзүүлсэн инфляц тооцооноор 2024 оны тооцоолол 920 ₮ дээр нэмэгдүүлэн бодоход хоолны зардал бодитоор 2200-2920 ₮ хооронд байна.

Санхүүжилтийн тодорхой хувийг эцэг эхчүүдээс гаргуулбал та дэмжих үү гэсэн асуултад нийт оролцсон 558 эцэг эхчүүдийн 60 хувь нь дэмжинэ гэсэн хариултыг өгсөн нь үдийн

Дүрс 4. Эцэг эхчүүдээс санхүүжилт гаргадаг туршлагыг нэвтрүүлбэл дэмжих эсэх



хоол хөтөлбөрийн хоолны зардал үнэхээр бага байгааг эцэг эхчүүдийн ихэнх нь хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлж байна. Дэмжиж байгаа шалтгаанаа угаасаа одоо өгч л байгаа, хүүхдээ сайн суралцуулахын тулд, хүнс үнэтэй болсон, өөрийн гэсэн гал тогоогүй, хоолондоо цагдаггүй гэсэн нээлттэй хариултаудыг өгсөн байна. Эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ бүх асуудлыг төрд, сургууль багш нарт даатган орхидог байдлаас хариуцлага хамт хуваалцах, нэмэр болох үйл ажиллагаанд оролцохыг илүүд үзэж байгаа нь анзаарагдлаа. АНУ, Япон, Солонгос зэрэг улсуудад ч хүүхдийн хоолны мөнгийг төр ганцаар хариуцаж бүх эрсдлээ үүрэх биш, эцэг эхчүүдээс тодорхой хувийг гаргуулснаар урт хугацааны хөтөлбөр үргэлжилж байгаа сайн туршлагыг Монгол улсад ч хэрэгжүүлэх хэрэгцээ хот хөдөөгүй байгааг эцэг эхчүүд илэрхийлж байна.


Дүрс 5. Тухайн аймаг суманд ‘Үдийн хоол’ хөтөлбөрийг хэрэгжүүлж буй өнөөгийн хэлбэрийг өөрчлөх шаардлагатай эсэх

	Мэдэхгүй	Маш чухал	Зарим талаараа	Чухал биш
Сайжруулах шаардлагатай	34.2%	65.1%	45.5%	42.4%
Заримыг нь сайжруулах шаардлагатай	38.0%	24.4%	42.9%	20.3%
Шаардлагагүй	3.8%	3.5%	3.7%	16.1%
Мэдэхгүй	24.1%	7.0%	7.9%	21.2%

Мөн үдийн хоол хөтөлбөрийн явагдаж байгаа өнөөгийн хэлбэрийг өөрчлөх шаардлагатай хэмээн эцэг эхчүүдийн 65.1 хувь нь хариулсан. Хүүхдүүд ангидаа хоолоо хүлээн авч иддэг, хүүхдүүдэд хоолоо идэхэд хангалттай цаг байдаггүй, хүүхдүүд хоорондоо ч чөлөөтэй ярилцах зав цаг гардаггүйн хамт өөрийн найз нөхөдтэйгээ найзлах боломж хомс зэрэг өнөөгийн хоол хөтөлбөр хүүхдүүдийн нийгмийн харилцааг дээшлүүлэхэд анхаарч чадахгүй байгааг эцэг эхчүүд анзаарсан байна. Томчууд бид хооллохоор гарахдаа хоолны сонголт, хамтарч ярилцах найз нөхөд, хооллох газрынхаа сонголт гээд олон сонголтыг хийснээр хоолыг зөвхөн 'гэдсээ дүүргэх, цадах' гэдэг утгаар бус хоолонд өгч байгаа утга нь шинэ харилцааг хөгжүүлэх, хуучин харилцаагаа бэхжүүлэх гээд цаад агуулга нь өөр байдаг. Хоолоор дамжих энэхүү агуулгыг хоол хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй бусад улс орнууд болох АНУ, Солонгос гээд бусад улс орнууд сайн хэрэгжүүлж, гал тогоо болон хоолны цаг нь хүүхдийн алжаал тайлах цаг гэсэн утгатай байдгийг манай улс анхаарах цаг болсон байна. Мөн хэлбэрийг өөрчлөх гэдгийн цаана амьжиргааны түвшнээр нь ялгамжтай хандах шаардлага байгааг эцэг эхчүүдийн хариултаас анзаарагдаж байна. Үдийн хоол хөтөлбөрийг сайжруулах шаардлагатай эсэхийг амьжиргааны түвшнээр ялгамжтай хандах, хоолны газар, хоолонд тавих хяналт зэрэг асуултаудтай уялдуулан судлахад тэдний 59.9 хувь нь хүүхдийн хоол хөтөлбөрийг эмзэг бүлгийн амьжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүдэд чиглүүлэхэд анхаарах, 56.5 хувь нь сургуулийн хоолны газрыг сайжруулах, 55.5 хувь хоолны чанар төрлийг олшруулах, 50.6 хувь нь хүүхдийн хоолонд тавих хяналтыг сайжруулах гэсэн хариултууд нь тус тус хамгийн өндөр хувьтай байна.

Манай улсын Ерөнхий Боловсролын 871 сургуульд 771.722 мянган суралцагч суралцаж байгаагаас үдийн хоолонд хамрагдаж байгаа нь 381481 (1212.mn, 2024) суралцагч 2023-2024 оны хичээлийн жилд үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. Судалгаанд оролцсон эцэг эхчүүд хоол хөтөлбөрийн өнөөгийн хэлбэрийг эцэг эхчүүдийн 56.1 хувь нь төрөөс одоо өгч буй нэг хүүхдийн хоолны зардлыг сурагч бүрийн нэр бүхий хоолны картанд оруулдаг, эцэг эхчүүд тухайн картанд нэмэлтээр мөнгө байршуулан, хүүхдүүдээ хоол идэх сонголттой болгоход анхаарах хэрэгтэйг онцолсон байна.


Дүрс 6. Эцэг эхчүүд үдийн хоол хөтөлбөрийг ямар хэлбэрээр дэмжин оролцох



Төрийн өмчийн 695 сургууль, хувийн 176 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Хувийн өмчийн сургуулиудаас үдийн хоол хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхдээ сурагч бүрийг өөрийн карттай

болгон, эцэг эхчүүд төлбөрийг хийн, сурагчид хоолоо сонгон иддэгээс амт чанарын хувьд хоолны үйлчилгээ явуулж буй бизнесийн байгууллагадаа дотоод хяналтыг буй болгосон төдийгүй, хоолны амт чанарын талаар сурагчид гомдол гаргах, мэдээлэх зэрэг үйлчлүүлэгч 'давуу' байх эрхээ эдэлж чадаж байгаа юм. Ийм сургуулиудын тод жишээ нь 'Орчлон' Хобби гээд олон сургуулиудыг нэрлэж болно. Хэдийгээр хувийн сургуулиуд төрөөс хүүхдийн хоолны зардал авахаа больсон ч сургуулийн хүүхдүүдийнхээ хоол хөтөлбөрийг зогсоох биш, харин ч хөгжүүлж, эцэг эхчүүд нь дэмжин, түүчээлэн ажиллаж байна.

Дүрс 7. Эцэг эхчүүд хоолны амталгаанд оролцож үзсэн эсэх (2018-2019 онуудад)



Нийт оролцсон эцэг эхчүүдээс 2018-2019 оны хооронд үдийн хоолны амталгаанд оролцож үзсэн 24.6 хувь буюу 137 эцэг эх, үгүй хэмээсэн нь 51.8 буюу 289 эцэг эхчүүд хоолны амталгаанд идэвхтэй оролцдоггүй, хяналтын зөвлөлийн үүргийг сургуулийн орчинд хэрэгжих байдал хангалттай биш байна хэмээн

дүгнэж болохоор байна.

Тухайн орон нутагт хэрэгжиж байгаа үдийн хоол хөтөлбөрийг сайжруулах хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулж хүйсийн хувьд ялгаатай байдлыг статистик тест шинжүүдээр шинжлэн үзэхэд р утга 0.13 буюу хүйсийн хувьд ялгаатай байдал ажиглагдлаа.

Дүгнэлт

- Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь ЕБС-ийн сургуулийн хоол үйлчилгээний хууль 2019 онд батлагдсанаар, түүнийг даган хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөр 2020 онд, үндэсний хөтөлбөрөө хэрэгжүүлэх төлөвлөгөө зэргийг батлагдсанаар баталгаажсан. Мөн Боловсрол Шинжлэх ухааны сайд, Эрүүл Мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал (А/166, А/559, 222) 2020 онд батлагдсанаар сургуулийн хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалат, цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг баталснаар даган мөрдөж ажиллаж эхэлсэн байна. Гэхдээ эдгээр баримт бичгүүдэд 'хоол' хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийг нийгмийн харилцаанд татан оруулах, бие даасан байдлыг нь нэмэгдүүлэх гэсэн чиг нийгмийн харилцааны талыг нь орхигдуулсан байна.
- Хуулийг хэрэгжүүлэх үүднээс дэвшүүлсэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хөтөлбөртөө гурван үе шатаар хөгжүүлэхээр зааж өгсөн. 2021-2030 оныг Эрүүл баталгаат орчин бий болгох, 2031-2040 оныг Амьдралын таатай орчин бүрдүүлэх үе шат, 2041-2050 Амьдралын хэрэгцээ хангагдсан орчин үе бүрдүүлэх гэсэн шатуудад хуваасан. Эдгээр шатуудад ч хооллох үед сурагчдын нийгмийн харилцааг сайжруулах тухай асуудлуудыг хөндөөгүй. Тиймд суралцангаа хоол идэх энэ практикийг дэлхий нийт хэрэгжүүлэхдээ нийгэмд харилцаанд сургаж байгаа нэг хэлбэр хэмээн ач холбогдол өгдөг туршлагыг оруулах хэрэгтэй байна.
- Хүүхдийн хоол хөтөлбөрийн зохион байгуулалтын хэлбэрийг улс орон бүрээр харьцуулахад, Монгол улс санхүүжилтийн эх үүсвэрээ дангаараа шийдэж байна. Тухайн

жилийн инфляцыг тооцохгүй нэрлэсэн үнээрээ нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг бодсоноор жил бүр инфляцид өртөж байгааг анхаарах. 2024 оны нэг хүүхдийн хоолны зардал 1500₮ бус 920 ₮ бодитоор хоол болж байна. Тиймд хуулинд заасан инфляц тооцон хүүхдийн мөнгийг олгодог болох шаардлагатай байна.

- МУИС-ийн Социологи Нийгмийн Ажил тэнхмийн судалгаа, Боловсролын яамны асуулгаас эцэг эхчүүд өдөрт 1357 ₮-2000 ₮ ийг хүүхдийнхээ үдийн хоолны зардалд нэмэгдэл болгон өгч байна. Тиймд нэг хүүхдийн хоолны бодит зардал 3000 ₮ орчим байгааг бодит байдал харуулж байна.
- Эцэг эхчүүдээс 558-ыг оролцуулсан судалгаанаас 60 хувь нь хоолны төлбөрт эцэг эхчүүд нэмэр хандив болох хүсэлтээ илэрхийлсэн. Энэ нь эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ бүх асуудлыг төрд, сургууль багш нарт даатган орхидог байдлаас хариуцлагаа хамт хуваалцах, нэмэр болох үйл ажиллагаанд оролцоход бэлэн байгааг харуулж байна.

Ном зүй

- (n.d.). Retrieved from <https://schoolnutrition.org/about-school-meals/school-meal-statistics/>
- БШУЯ. (2020). *Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ*. Бага дунд боловсролын газар, Улаанбаатар.
- БСШУЯ. (2023, 07 07). *Боловсролын ерөнхий хууль*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын хамтарсан тушаал. (2020, 12 02). *Норматив батлах тухай*. Улаанбаатар .
- Association, S. N. (2024, 04 09). *Schoolnutrition.org*. Retrieved from School Nutrition Association: <https://schoolnutrition.org/about-school-meals/school-meal-statistics/>
- Dugarsuren, O. (2011). *Improving school attendance and supporting micronutrient intake: A critical review of the effectiveness of the Mongolian School Feeding program*. Master's thesis. Australia: Centre for Health&Society8 Melbourne School of Population Health, Faculty of Medicine, Dentistry & Health Sciences, The University of Melbourne.
- Ministry of Education, C. a. (2006). *Master Plan to Develop Education of Mongolia in 2006-2015* . Ulaanbaatar: MOE.
- Murayama, N. (2022). International Food Policy Research Institute . *The 8th Tokyo International Conference on African Development (TICAD8)*. Tokyo.
- UNICEF. (2006a). *Multiple Indicator Cluster Survey*. Ulaanbaatar: NSO.

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ХҮРЭЭНД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

М.Батбаатар

*МУИС, ШУС, Социологи, нийгмийн ажлын тэнхим,
дэд профессор, ORCID:0000-0001-5308-324X*

Б.Долгор

Жендерийн Үндэсний шинжээч

Summary: *In this article, the fulfillment of the obligations assumed at the international level in the field of ensuring gender equality in the political sphere of Mongolia and the implementation of the system for ensuring gender equality in the country were considered. It is based on international agreements of Mongolia, the Constitution of Mongolia, the Law on Ensuring Gender Equality/Gender Equality, and other laws and regulations. In doing so, how gender equality is implemented in the political sphere is evaluated and analyzed.*

Key words; *gender equality, mainstream, system, political sphere*